

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

**ХЯТАДЫН ТҮҮХИЙН СУРВАЛЖ БАРИМТЫН
ТУХАЙ****Н. Ишжамц,**

ШУА-ийн сурвалжлагч гишүүн

БНХАУ бол олон мянган жилийн түүхтэй, эртний соёлт орны нэг юм. Шургуу хөдөлмөрч, эрх чөлөөнд дуртай хятадын ард түмэн эзэрхэг түрэмгий ба хөрөнгөтөн-газрын эздийн дарлалтай удтал баатарлаг тэмцэж, 1949 онд ардын хувьсгал мандуулсан билээ. хүн, ардын төр нь эх орны хөгжлийн жолоог социализмын зүг залж, ЗХУ зэрэг социалист улсуудын тусламж дэмжлэгээр багагүй амжилтанд анх хүрч байв. ХКН ын XII их хурал дээр Маогийн бурангуй үзлийн хэт дэвэргэсэн зарим зүйлээс татгалзан, «соёлын хувьсгал» гэгчийн балмад үйл ажиллагааг буруушааж, улс орны дотоодыг цэгцлэх, социалист орнуудтай харилцаагаа хэвийн байдалд оруулах тухай дурьдсан. БНХАУ-д марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын үзэл хэдий түргэн сэргэж, дотоод, гадаад бодлогод социалист ёс хичнээн тууштай хэрэгжих тутам хятадын ард түмний амьдрал, хөгжлийн ирээдүйн төлөв төдий чинээ саруул гэгээн болох нь дамжиггүй.

БНХАУ-ын эрт, эдүгээгийн түүх, хятадын ард түмний амьдрал хөгжлийн ээдрээтэй асуудал, баатарлаг тэмцлийн ололт амжилтыг судлан боловсруулахад тулгуурлах эх сурвалжийн баримт маш арвин юм. Сурвалж баримтын зүйлсийг 1-рт археологийн дурсгал, эдийн боловсролын материал, 2-рт, бичиг дурсгалын зүйл гэж үндсэнд нь хоёр чиглэлээр ангилан үзэж болно.

Марксист түүхчид хятадын түүхийг судлан боловсруулахдаа түүний эх сурвалжуудыг эрдэм шинжилгээний үндэстэй задлан шинжилж материалист диалектик, түүхэн материализмын үүднээс нэгтгэн дүгнэж, алив үзэгдэлд үнэн мөнийг олсон ул үндэстэй дүн шинжилгээ хийхийг эрхэмлэдэг юм.

Хятадын түүхийн хамгийн эртний дурсгалууд нь археологийн шинжилгээгээр нээгдэн гарч ирсэн юм. 1921 онд хятадын археологич Пэй Вэньчжүн Бээжингийн орчим дахь Чжокоудянь толгодын агуйнуудаас хуучин чулуун зэвсгийн доорд шатны үед оршиж амьдарч байсан балар эртний мичин хүний гавлын яс, багаж зэвсгийн зүйл илрүүлж олсон байна. Тийм мичин хүн Хятадад одоогоос 500-гаад мянган жилийн өмнө амьдарч байсан нь үүгээр тодорсон бөгөөд шинжлэх ухаанд синантроп «хятадын хүн» гэж алдаршсан юм.¹ Энэ бол хятад оронд хүн оршин амьдарч, эхэлсэн эрин үеийн баримжааг тогтоож өгсөн хятад эрдэмтдийн судалгааны чухал ололт, томоохон нээлт болсон юм. Ардын хувьсгалын дараа 1963 онд төв хятадын Лантянь нутгаас бас нэг мичин хүний эрүүний яс сэлтийг олсон нь синантропоос арай эрт үед оршин амьдарч байсан учир мөн судалгааны ихээхэн чухал баримт болсон байна.

¹ Бай Шоуи, Хятадын ерөнхий түүхийн хураангуй. Бээжин 180. 26-27-р тал

Мичин хүн бол дөрөвдөгч галавын эцэс үеийн хүн дүрст мичнээс хөдөлмөрийн ачаар хүн болж ялгаран хөгжсөн балар эртний мичин маягийн хүн байв. Африкт тийм мичин хүн 4 сая жилийн өмнө үүсэн гарч байсны ул мөр олдоод байна. Зүүн өмнөт Азиас, тухайлбал Явын арал дээр нэг сая жилийн өмнө оршиж амьдарч байсан питекантрол хэмээх тийм мичин хүний ясны үлдэгдэл XX зууны эхээр анх олдсон юм. Африк, Хятадаас олдсон эдгээр мичин хүмүүс цөм питекантропын аймагт хамаарах юм.

БНМАУ-ын нутагт одоогоос 3-4 зуун жилийн өмнө мөнхүү тийм мичин хүн оршин амьдарч байсны ул мөр, хэрэглэж байсан өвөрмөц чулуун багаж зэвсгийг А.П. Окладников тэргүүтэй зөвлөлт, монголын эрдэмтэд 1960-аад оны үест илрүүлж олсон. 1956 онд Өвөр Монголын Их зуу аймаг буюу Ордосын Өөшийн хушууны нутгаас хуучин чулуун зэвсгийн доорд шатны мичин хүний дагз, шилбэний яс олдсон зэрэг нь Цагаан хэрмээс хойших Төв Азийн бүс нутгийн нэгэн хэсэгт, түүний дотор мөн Монголд хүн оршин амьдарч байсан эхний үеийн байдал төлөвийг тодруулсан чухал нээлт болсон юм.

Энэ бүхэн нь балар эртний үед одоогийн Зүүн Өмнөт Ази, Хятад, Монгол нутагт тус бүрдээ онцлог бүхий хуучин чулуун зэвсгийн доорд шатны мичин хүмүүс оршин амьдарч, тус тусын өвөрмөц амьдрал, ссёлып эх үүсвэрийг тавин хөгжүүлж байсныг нотолж байгаа юм.

Хувьсгалын дараа Пэй Бэньчжун, Цзя Ланьпо нарын зэрэг археологич нар мөнхүү Чжокоудянийн агуйнуудаас синантропоос үүсэл бүхий хуучин чулуун зэвсгийн дунд шатны заримдаг мичин хүн 100—40 мянган жилийн өмнө оршин амьдарч байсны ул мөр, багаж зэвсгийн зүйл олныг олсон байна. Заримдаг мичин хүн нь питекантроп, синантропыг бодвол бие махбод, оюун санааны ба үйлдэх бүтээх авьяас чадвараар мэдэгдэхүйц давуу хүн нийгмийн хөгжлийн дараах шатны хүн байсан бөгөөд нэгэнт гал гарган хэрэглэж чаддаг болоод байсан нь түүний чухал ололтын нэг байсан юм. Заримдаг мичин хүнийг шинжлэх ухаанд «неандерталийн хүн» гэж нэрлэдэг. Неандерталийн хүний ул мөр, багаж зэвсгийн зүйлс Хятадад цөөнгүй олдоод байгаагийн дээр Зүүн Өмнөт Ази, Монгол, түүнчлэн мөн дундад Азийн зэрэг Ази, Европын олон нутгаас багагүй олддог байна.

Заримдаг мичин хүн чулуун багаж зэвсэг үйлдэж, гал хэрэглэн амьдарч хөдөлмөрийн ачаар улам улам боловсрон хөгжсөөр бие махбод, сэтгэхүйн хувьд хуучин чулуун зэвсгийн дээд шатны «хомо сапиенс» хэмээх жинхэнэ хүний төрхийг олсон байна. Орчин үеийн хүний төрхийг бүрэн олсон хуучин чулуун зэвсгийн дээд шатны тийм хүн амьдарч хөгжиж байсны ул мөр, БНХАУ-ын хятад мужууд, бусад орны нутгаас цөөнгүй олдсон юм. Хуучин чулуун зэвсгийн дээд шатны үед хүн анх нохой тэжээж хэрэглэх болж, гэрийн тэжээвэр амьтан-хожмын мал үүсэх эх суурь тавигдах байдал харагдсан байна.

Хятадад нийгмийн хөгжлийн дараачийн шатын зүлгэн зассан шинэ чулуун зэвсгийн дурсгал их хэмжээгээр олддог юм. Анх 1921 онд Шведийн эрдэмтэн И.Андерсан Шар мөрөн буюу Хатан голын дунд урсгалын Яньшао гацааны орчмоос хятадын шинэ чулуун зэвсгийн үеийн багаж зэвсэг зураас шавар савны зүйл нээж олсон байна. М.Э.Ө. V—IV мянганы үед байсан тэрхүү шинэ чулуун зэвсгийн дурсгал нь шинжлэх ухаанд анх олдсон газрын нэрээр «Яньшаогийн соёл» гэж алдаршсан юм. Мөн сүүлийн үед Ханшуэй голын сав дахь Цзюйцзялин, Хатан голын дээд урсгалын Мацзяяо. Өвөрмонгол, Синьцзян зэрэг газраас шинэ чулуун зэвсгийн дурсгал аж ахуй багаж хэрэгсэл ихээр олдоод байна. Өвөр монгол, Синьцзяны зүүн хойт хэсгээс олдсон шинэ чулуун зэвс-

гийн зүйлс манай улсын нутаг дэвсгэр дээрээс арвин олддог Монголын шинэ чулуун зэвсгийн дурсгалтай олон талаар ойр төсөөтэй үзэгдэнэ. Хятадад Яньшаогийн соёл дэлгэрэн хөгжиж байхад Өвөрмонгол, Зүүнгар, Халхын нутагт бас нэг зүйлийн шинэ чулууны өндөр соёл зэрэгцэн оршиж байжээ. Шинэ чулуун зэвсгийн үеэс, ялангуяа түүний сүүлч үе хүрэл зэвсгийн эхэн үеэс газар зүй, уур амьсгалын өвөрмөц нөхцөл байдал зэргээс шалтгаалж Хятад Монголын аж ахуй, эдийн засаг, соёлын ялгаа нэн тодорч ирсэн байна. Хэрэв шинэ чулууны эхэн, дунд үед хятад монголын аль алинд газар тариалан, гэрийн тэжээвэр мал бараг нэгэн зэрэг үүсч холимог байдлаар оршиж байсан бол шинэ чулууны сүүлч, хүрлийн эхэн үеэс Хятадад газар тариалан, Монголд мал аж ахуй улам улмаар түлхүү хөгжиж зонхилох хандлага ажиглагдсан байна.

Хүрэл төмөрлөг зэвсгийн үе Хятадад М. Э. Ө. IV мянганы үед эхэлсэн бөгөөд тэр үед газар тариалан, гар урлал ахицыг олж, М.Э.Ө. III мянганы эцэст хөрөнгө чинээ, баян ядуугийн ялгаа гарч, улмаар хятадын анхны ангит нийгэм, төр улс үүсэх нөхцлийг бүрдүүлж байв. М.Э.Ө. XXI зууны үед эртний хятадын боол эзэмшигчдийн Ся улс хэмээх төр үүсч, М.Э.Ө. XVI зууныг хүртэл оршин тогтноод мөхсөн байна. Тэр үеийн археологийн дурсгал саяхан болтол олдоогүй байсан боловч уржнан жил хятадын археологч нар Ся улсын үеийн хүрэл зэвсэг, сав суулгын зүйлийг анх олж тухай мэдээг ноднин нийтэлсэн юм. Хятадын хүрэл багаж зэвсэг, сав суулга, гоёл чимэглэлийн зүйл дараах Шан Инь улс (М.Э.Ө. XVI—М.Э.Ө. XI зуун), Чжоу (М.Э.Ө. XI—М.Э.Ө. III) улсын үед нарийн хөгжсөн байна. Инь улсын нийслэл Шан хот, мөн баруун Чжоу улсын тосгон, булш бунхны дотроос олдсон хүрэл эдлэл нь эртний хятадын иргэншилт соёлын дээж болж байгаа юм.

Хятадын Ся, Инь улсын үед Монгол нутагт мөн хүрлийн соёл хөгжиж, нүүдлийн мал аж ахуй зонхилон хөгжөөд Чжоу улсын сүүлч үеэр Ордос, Халх, Зүүнгар, Төвд зэрэг газар оронд амьтны дүрст хүрлийн өвөрмөц өндөр соёл бий болсон байна.

Зүүн Чжоу (М.Э.Ө. VIII—М.Э.Ө. V зуун), ялангуяа байлдаант улсын (АА.Э.Ө. V—III—зуун) үеийн Хятадад төмөр боловсруулах арга ажиллагаа үүсэн хөгжиж, эртний хятадын эдийн засаг, соёлын хөгжилд ээлжит томоохон ахиц гарсан байна.

Эртний Хятадын боол эзэмшигчдийн анхны эзэрхэг эзэнт гүрэн Цинь улс (М.Э.Ө. III зуун), түүнчлэн мөн боол эзэмших ёс задран мөхөх үеийн Хан улсын (М.Э.Ө. III—М.Э. III зуун) үе болон хойших бүх үеийн түүхийг судлахад ч гэсэн археологийн дурсгал маш чухал хэрэглэгдэхүүн болдог.

Гэвч Хятадад анхны ангит нийгэм, төр улс бий болох үеэс, ялангуяа Инь, Чжоу улсын үеэс эхлэн бичиг дурсгалын зүйл жилээс жилд улам илүү ач холбогдолтой болсоор ирсэн байна. Эртний Хятадын Ся, Инь улсын үед юмны зургаас үүдэн гарсан дүрс үсэг, утга бичиг буюу йероглифт бичиг үсэг үүсэн хөгжсөн байна. Инь улсын үеийн яст мэлхийн бамбай ясан дээр сийлбэрлэсэн мэрэг төлгийн дүрс үсэг Чжоу улсын хүрэл эдлэл дээрхи утга бичиг нь эртний хятадын түүхийн бичиг дурсгалын бодит баримт болж байна.

Инь улсын үеийн түүхийн холбогдолтой сурвалж бичгийн зүйлээс «Шаншу» буюу «Шүцзин» хэмээх түүх, домог, аман зохиол, соёлын дурсгал зохиол, Чжоу улсын үеийн «Шицзин» хэмээх 300 гаруй дуу, шүлэг багтаасан эмхэтгэл, «Ицзин» хэмээх түүх, соёл, уран зохиолын дурсгалыг дурдаж болно.²

² Цзинь Юйфу. Хятадын түүх судлалын түүх. 1962. с. 20-36.

М.Э.Ө. VI—М.Э.Ө. II зууны Хятадын боол эзэмшигчдийн улс гүрнүүдэд Лаоцзы хэмээх материалист гүн ухаантны сургаал, Күнз мэргэн хэмээн алдаршсан Конфуцийн суртал, «Фацзя» хэмээх цааз хуулийн номлолтын номлол, «Хуайнаныцзы» хэмээх улс төр, гүн ухааны зохиол, «уул усны судар», «Хулсан ном» зэрэг олон зохиол зохиогдон гарсан нь эртний хятадын түүхийн холбогдолтой чухал сурвалж болдог юм. Лаоцзын ёсны даосын сургаал нь боол эзэмшигчдын дарлал, ван ноёд, томоохон газрын эздийн эсрэг, хувийн өмчийн эсрэг хүй нэгдлийн байгууллын үеийн нийгмийн өмчит ёс, эрх тэгш, эрх чөлөөтэй байдлыг сэргүүлэн тавьж, хөршийн хүй нэгдлийн гишүүдийн үл хоосрон ядуурах эрх ашгийг хамгаалан илэрхийлсэн эсэргүүцлийн илрэл байв. Күнзийн суртал «Дөрвөн ном, таван бичиг» буюу Их, бага суртхуй зэрэг нь боол эзэмшигчдийн төрийн тэргүүн вангуудын эзэрхэг засгийг хязгаарлаж, эцгийн эрхт ёсны үлдэгдэл, хуучны уламжлалыг хамгаалан, язгууртны эрх мэдлийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байв. «Цааз хуулийн номлолтон» нар хувийн өмч, баян ядуугийн ялгааг гүнзгийрүүлж, эзэрхэг засгийн ёс, хааны төр, түшмэдийн хүч нөлөөг нэмэгдүүлэн хатуу ширүүн хуульд тулгуурласан чанга гарын засаг тогтоохыг сурталчилж байв. Даосын ёс, цааз хуулийн номлол, ялангуяа Күнзийн суртал нь боол эзэмших ёсны хожуу үе, феодалын хятадын улс төр, эдийн засаг, соёлын бүх салбарт гүн гүнзгий нөлөө үзүүлсэн, түүгээрээ бас түүхийн чухал сурвалж болж явдаг юм. Түүнээс гадна Күнзийн бичсэн «Цюньцю (хавар намар)» зохиол нь эртний хятадын сант улсуудын нэгэн болох Лу улсын түүх учир нэн чухал сурвалж мөн. Күнзийн зохиолуудад төр засаг, ёс суртахууны номлол голлох боловч хятад төвийн үзлийн зүйл орсон нь хятадын боол эзэмшигчид, феодал-хөрөнгөтний төрийн эрх баригчдын түрэмгий бодлого, Маогийн жанжлах үзэлд тусгалыг олж харш буруугар ашиглагдаж ирсэн талтай.

Эртний хятадын хан, вангуудын ордонд өдрийн тэмдэглэл байнга хариуцан хөтөлдөг сударч түшмэд байдаг байсан бөгөөд тэрхүү уламж лалын үндсэн дээр Баруун Хан улсын үеэс эхлээд хятадын угсааны төрүүдийн түүхийг зохион гаргах болсон байна. Анх М.Э.Ө. 94 оны үест Сыма Цянь хэмээх ордны эрдэмтэн сударч түшмэл балар эртний үеэс өөрийн үеийг хүртлэх хятадын түүх зохиож «Шицзи түүхийн тэмдэглэл» хэмээн нэрлэсэн байна. «Түүхийн тэмдэглэл» бол 5 хэсгээс бүрдсэн 130 бүлэг бүхий томоохон түүхийн сурвалж зохиол юм. Түүний зохиол хаад ноёд, мөлжигч ангийн эрх ашгийг хамгаалсан талтай боловч түүхийн баримтыг бодит байдлаар тусгахыг чухалчилсан үнэтэй сурвалж мөн болно. Сыма Цянь өөрийн зохиолд Хятадтай хөрш зэргэлдээ оршиж, найрамдах дайтах, харилцан элч зарах, худалдаа хийх зэргээр харилцаж байсан Хүннү гүрэн, түүнчлэн бусад улс аймгуудын түүх, соёл, зан заншлын тухай мэдээ баримтыг тусгай бүлэг зүйл болгож хавсарган бичсэн нь эртний Монголын түүхийг судлахад бичиг дурсгалын үнэт сурвалж болж өгдөг. Тэхдээ Сыма Цянь Хүннүг Хятадын ямар нэгэн «салшгүй хэсэг», «харьяа газар», «хараат аймаг» болгож дүрсэлсэнгүй, харин хилийн гаднах харь аймаг, гадаад улс орон байж, нэг үе Хан улстай эн сацуу, эрх тэгш харилцдаг хүчирхэг гүрэн байв хэмээн түүхэн үнэнийг бодитой тусган үлдээсэн байдаг юм.³ Сыма цяний. «Түүхийн тэмдэглэл», түүний маяг, хэлбэр, арга барил нь эрт, дундат ба шинэ үеийн хятадын угсааны төрүүдийн түүхийг зохиох загвар болсон байна. М.Э. I зууны үед Бань Гүгийн зохиосон «Баруун Хан улсын судар», V зууны үед Фань Е-гийн зохиосон «Зүүн Хан улсын судар»

³ Сыма Цянь. Түүхийн тэмдэглэл. 110-р бүлэг

зэрэг нь чухам тийм загвар маягаар зохиогдож, Хүннү, Сяньби болон монгол угсааны бусад улс аймгийн түүхийг гадаад харь орны тухай мэдээ сэлтийн тусгай бүлэг зүйл болгож номын зохих хэсгүүдэд хавсаргасан байдаг байна.

Чэнь Шоугийн зохиосон «Гурван улсын түүхэн ойллого», Вэй Шоугийн «Вэй улсын судар», Вэй Чжэнгийн «Сюй улсын судар», түүнчлэн мөн Тан, Сүн, Ляо, Алтан улс, Юан, Мин, Манж Чин улсын түүхүүд нь цөм эзэн хааны ордонд эмхлэн зохиосон дундад зууны ба шинэ үеийн феодалын Хятадын угсааны төрүүдийн албан түүх судрын зүйлс болох бөгөөд Хятадын улс төр, эдийн засаг, соёл, шашин ба гадаад харилцааны түүхийн чухал сурвалжууд юм. Угсааны төрүүдийн тийм түүх судар нь феодал ангийн эрх ашгийг хамгаалж, бусад улс түмний түүх, соёлыг басамжлан үгүйсгэх эзэн хаадын жанжлан ноёлох түрэмгий бодлогыг нэг биш удаа илэрхийлсэн байх учир түүнд шүүмжлэлтэй хянуур хандах нь зүйтэй. Тэдгээр зохиолд Монгол зэрэг гадаад орнуудын түүхийг судлахад чухал зарим баримтыг бүлэг зүйл болгон хавсаргасан байдаг. Гэвч феодалын хятадын түүхчид дотоод, гадаад, Хятад, Монголыг хэзээд хольж хутгахгүй, үргэлжид тодорхой зааглан үзэж, харийн байлдан дагууллыг гол төлөв жигшин үзэх үзлийн үүднээс бүтээлээ туурвисан байдаг юм. Тийм учир Хятадын албан түүх, ордны судрууд ч гэсэн чухамдаа харь орныг түрэмгийлэн эзлэхийн түүхэн үндэс болохгүй, харин бусад улс орон тус тусдаа биеэ даасан түүхтэй, өвөрмөц хэл соёлтой аймаг угсаатан байсаар ирснийг гарцаагүй болтол яв цав нотлож байгаа юм. Энэ асуудлыг өөрөөр урвуулан тавихын хамт түүхийг завхруулах явдал болдгийг амьдрал нотлосон юм. Түүхийн баримтыг төрийн бодлогын улмаас санаатай гуйвуулбал хамгийн наад зах нь улс түмнүүдийн өнгөрсөн үеийн найрамдалт харилцааны асуудлыг тавихад хүртэл саад бэрхшээл учруулдаг юм.

Угсааны төрүүдийн түүхээс гадна Хятадад «Миншилү Мин улсын үнэн магад хууль» «Чин улсын үнэн магад хууль» гэх зэрэг дэлгэрэнгүй тодорхой түүхийн сурвалжууд байдаг. Тийм зохиол нь хэдийгээр «хууль» гэж монголоор орчуулагддаг уламжлалтай боловч хэрэг дээрээ түүхийн доривлог эмхэтгэлүүд юм.

Мин, Чин улсын түүхийн архив маш арвин бөгөөд хятад, манж, монгол, төвд, уйгур, орос, европын хэлнүүд дээрхи янз бүрийн баримт энд цуглагдсан байдаг. Бээжин, Мүгдэн Нанкин, Хөх хот, Лхаса, Үрүмч зэрэг хотууд, мөн мужийн төвүүд нь тус тусдаа архивтай.

Эрт, дундад ба шинэ үеийн хятадын түүхчдийн туурвисан ерөнхий түүхийн зохиолууд, хувь хүний бичсэн түүх, жуулчдын замын тэмдэглэл, шашны ном зэрэг бусад олон зүйлийн бичиг дурсгалын сурвалж байдаг. Тэдгээрийн дотроос алдартай нь XI зууны үед түүхч Сыма Гуаны зохиосон «Цзычжи Түнцзянь Төр жолоодох ёсны нэвтэрхий толь», XIII зууны эрдэмтэн Ма Дуяньлиний «Вэньсянь түнкао» (Утга, бодролын цомирлог), XIX зууны сүүлчээр Ван Сянцяний зохиосон «Арван нэгэн төрийн Дүнхуалу бичиг» гэх зэргийг дурдвал зохино.

Мөн «Их Юан улсын богд хууль», «Дайчин улсын бүгд хууль ба хууль зүйлийн бичиг» гэх хэрэг янз бүрийн цааз хуулийн дурсгал нь бас түүхийн чухал сурвалж болж өгдөг.

Хятадын түүхийг судлахад XIII зууны Италийн жуулчин Марко Пологийн замын тэмдэглэлийн дурсамж зохиол,⁵ түүнчлэн хойч үед

⁴ Тэдгээрийн дотроос Киданы «Ляо улсын түүх», Зүрчидийн «Алтан улсын түүх» хоёрыг Юан гүрний үеийн Монгол эрдэмтэн Тогтох зохиосон юм.

⁵ Книга Марко Поло. М., 1956.

Хятадад ирж сууршсан буюу ирээд буцсан өрнөдийн загалмайтны шашны суртал номлогчдын янз бүрийн тэмдэглэл зэрэг гадаад сурвалж бичгийн зүйлс анхаарагдан хэрэглэгддэг. Гэвч ялангуяа католик шашин номлогчдын гараас гарсан бичгийн дурсгалд буруу ойлгож эндүүрч ташаарсан, анги нам, арьсны үзлийн үүднээс зориуд мушгин гуйвуулсан зүйлс тохиолдлыг анхаарах хэрэгтэй.

1911 оны хятадын хөрөнгөтөний хувьсгалын дараа байгуулагдсан «Дундад иргэн улс» хэмээх хөрөнгөтөн-газрын эздийн Хятадын бүгд найрамдах улсын түүхийн талаар архивын баримт, эмхэтгэл зохиол, элдэв тэмдэглэл, данс хараа зэрэг олон төрлийн сурвалж бичиг байдаг.

ХКН, БНХАУ-ын түүхийн сурвалж гэвэл ХКН-ын их, бага, бүгд хурлын баримт бичиг, программ дүрэм Ли Дачжао зэрэг ХКН-ыг үндэслэн байгуулагч удирдах ажилтан нарын үлдээсэн баримт бичгүүд, БНХАУ-ын үндсэн хууль зэрэг хууль тогтоомж, төрийн зөвлөл засгийн газар, яамд, аж ахуй, соёл, шинжлэх ухаан, урлаг-уран сайхны газруудын баримт бичиг, дотоод хэрэгцээ, гадаад харилцааны албан баримтууд зэрэг маш баялаг сурвалж материал бий. Хятадын уугуул мужуудаас гадна үндэсний районуудад хувьсгалын дараах БНХАУ-ын төв, орон нутгийн түүхэнд холбогдох сонин бөгөөд чухал бичиг баримт бас байдаг.

Энэ бүхэн нь ХКН, БНХАУ-ын түүх, хятадын ард түмний үндэсний тусгаар тогтнол, нийгмийн эрх чөлөөний төлөө явуулсан хувьсгалт тэмцэл, социализм байгуулах зорилт бүхий бүтээлч шаргуу хөдөлмөр, түүний ололт амжилт, одоогийн байдал, ирээдүйн төлвийг онол, эрдэм шинжилгээний ул үндэстэй судлан боловсруулахад бүрэн хүрэлцэх баттай хэрэглэгдэхүүн болох юм.

О ПЕРВОИСТОЧНИКАХ ПО ИСТОРИИ КИТАЯ

В статье дается общая характеристика археологических находок и письменных источников, отражающих историю Китая и его отношения с другими странами. Открытие тинантропа и других археологических данных имеет важнейшее значение для изучения дописьменной истории Китая. Что же касается письменных источников, то в идограммах и иероглифических надписях на кости, в «Шаньцзу», «Ицзин» и других ранних историко-литературных и философских произведениях ярко отражены события древней и древнейшей истории Китая.

В династических хрониках и официальных документах, как и в произведениях китайских авторов древности и средневековья, мы находим подробные сведения о первобытном, рабовладельческом и феодальном Китае.

Следует отметить классовый, феодально-помещичий, тенденциозный характер династических историй Китая и необходимость критического подхода к ним. Несмотря на это, на основе китайских исторических источников можно воссоздать объективную историю Китая, создавшего одну из древнейших цивилизаций в мире. Характерно, что китайские источники в большинстве случаев правильно отображают историю и характер отношений с Китаем, Монголией и других сопредельных стран как историю суверенных государств, и имевших свою самобытную культуру. Всякие попытки доказать обратное сослываются на данные древних китайских источников научно несостоятельны и оборачиваются фальсификацией истории. Только объективный, марксистско-ленинский подход к истории и историческим источникам ведет к поиску и установлению объективной истины.